| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,740,500.00 | 14,740,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,685,200.00 | 3,685,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 36,851,300.00 | 36,851,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 157,876,000.00 | 157,876,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,241,000.00 | 3,564,083.00 |
| 210302 | Түлш, халаалт | 149,414,000.00 | 154,211,917.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,221,000.00 | 100,000.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,936,600.00 | 15,936,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 875,600.00 | 875,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,225,000.00 | 1,225,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,571,400.00 | 2,571,400.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,250,900.00 | 1,250,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,013,700.00 | 10,013,700.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 102,671,700.00 | 97,309,925.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 731,200.00 | 731,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 95,186,600.00 | 89,824,825.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,753,900.00 | 6,753,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,000,700.00 | 452,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,000,700.00 | 452,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,850,900.00 | 1,850,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,250,900.00 | 1,250,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 600,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | |
| 210807 | Газрын төлбөр | | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,043,700.00 | 13,043,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,043,700.00 | 13,043,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 105,742,500.00 | 105,742,500.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 105,742,500.00 | 105,742,500.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 105,742,500.00 | 105,742,500.00 |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,490,432,800.00 | 2,481,779,720.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,331,556,800.00 | 2,322,903,720.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,331,556,800.00 | 2,322,903,720.00 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 158,876,000.00 | 158,876,000.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 158,876,000.00 | 158,876,000.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 158.00 | 159.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 103.00 | 104.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 52.00 | 52.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 2.00 | 2.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 1,680.00 | 1,680.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 1,680.00 | 1,680.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 1,680.00 | 1,680.00 |
| 630002 | Хувийн ЕБС | | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **158.00** | **159.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | | |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | | |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | | |

| | | | |
|---|---|---|---|
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 113.00 | 113.00 |
| 650005 | ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | | |
| 650006 | Соёл урлагийн салбарын тєрийн ïйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 2.00 | 2.00 |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | | |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1.00 | 2.00 |
| 650009 | Тєрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 42.00 | 42.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | | |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **1,462,202.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **1,462,202.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 1,462,202.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 1,462,202.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 912,202.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 550,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 1,462,202.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 1,462,202.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,462,202.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн нь бага дунд боловсрол олгох, боловсролын талаарх төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн үйлчилгээний байгууллага юм.

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх,чанартай сургалт олгох зорилго тавьж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 6 гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2510.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 37.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 28.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 92.0 сая төгрөгөөр буюу 5.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 2.6 | 1.9 | -0.7 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 63.2 | 60.3 | -2.9 |
| Нөөцийн бараа | | | |
| Үндсэн хөрөнгө | 1693.9 | 1605.4 | -88.5 |
| **Нийт хөрөнгө** | **1759.6** | **1667.6** | **-92.0** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1759.6 | 1667.6 | -92.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1759.6** | **1667.6** | **-92.0** |

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Тайлант оны эхэнд 2.6 сая төгрөгийн НДШ-тэй холбоотой авлага байсныг тайлант онд барагдуулжээ. Өмнөх оны аудитаар 1.6 сая төгрөгийн татварын авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байсанд албан шаардлага өгөгдсөнийг татварын тооцоонд оруулж барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 60.3 сая төгрөг болж оны эхнээс 2.9 сая төгрөгөөр буурсан нь оны эхний үлдэгдлээс зарцуулсан холбоотой байна.Тайлант онд төсвийн хөрөнгөөр 125.0 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 117.7 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, аж ахуйн материал 10.2 сая төгрөгийн бараа материалыг акталж устгасан байна.

Оны эцэст бараа материалын үлдэгдлийг төрлөөр нь авч үзвэл бусад хангамжийн материалын үлдэгдэл 4.6 сая төгрөгөөр, хүнсний материалын үлдэгдэл 8.9 сая төгрөгөөр өссөн байна.Бичиг хэргийн материал, аж ахуйн материал, түлш, шатах тослох материал, барилгын засварын материалын үлдэгдэл 1.1-12.5 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 88.5 сая төгрөгөөр буурсан байна.Тайлант онд төсвийн хөрөнгөөр 5.7 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, бусад эх үүсвэрээр 71.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсныг бүртгэлд тусган ажилласан байна.Нийт 82.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгөнөөс аймгийн ИТХ-ын 2021 оны 12 сарын 30-ны өдрийн 133 дугаар тогтоолоор 30.7 сая төгрөгийг, сумын ИТХ-ын 2021 оны 12 сарын 27-ны өдрийн 63 дугаар тогтоол, 2021 оны 12 сарынг 08-ны 55 дугаар тогтоолоор 52.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, аймгийн ИТХ-ын 2021 оны 10 сарын 28-ны өдрийн 84 дүгээр тогтоолоор 4.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад төсөвт байгууллагад шилжүүлэн ажилласан байна.

Сургуулийн захирлын 2021 оны 12 сарын 31-ний өдрийн 67 дугаар тушаалаар акталсан хөрөнгийг устгах комиссын бүрэлдэхүүнийг байгуулж, Өмч хамгаалах зөвлөлийн 2022 оны 3 сарын 03-ны өдрийн актаар он удаан жил ашиглаж, ашиглалтын хугацаан дуусч, ашиглах боломжгүй болсон 82,8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг, 10.7 сая төгрөгийн бараа материалыг шатааж устгасан байна.

Биет бус хөрөнгийн дүнд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр данс оны эхэн болон эцэст үлдэгдэлгүй байна. Тус газарт урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 92.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд -92.0 сая төгрөгийн үр дүнтэй гарснаас шалтгаалжээ. Засгийн газрын капиталын дүнд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 159.7 сая төгрөгөөр буюу 6.6 хувиар өссөн байна. Урсгал санхүүжилтийн орлого өмнөх оноос 174.9 сая төгрөгөөр буюу 7.5 хувиар өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 144.7 сая төгрөгөөр буюу 5.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, НДШ, хангамж бараа материалын зардал, бусад урсгал шилжүүлгийн зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүнд ямар нэгэн залруулга хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн анхны төсвийг 2374.7 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 2490.4 сая төгрөг болгон өөрчилж анх баталсан төсвөөс 115.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Энэ нь анх баталсан төсөвт цалингийн зардлыг 102.0 сая төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийг 29.0 сая төгрөгөөр дутуу суулгасан, 113.0 сая төгрөгийн урамшууллын зардлын төсвийг төсөвт суулгаагүй байсантай холбоотой байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн 18 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2490.4 сая төгрөгийн төсөв батласнаас 158.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 2331.6 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр төсвөөс нийтдээ 2490.4 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2481.8 сая төгрөгийг зарцуулж, үндсэн санхүүжилтээс 8.6 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тусгай зориулалтын шилжүүлгээс 2322.9 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 158.9 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2481.8 сая төгрөг буюу 99.6 хувьтай байна.

Нийт төсвийн 74.0 хувийг цалин, 10 хувийг НДШ-ийн зардал, 6.4 хувийг тогтмол зардал, 0.6 хувийг хангамж бараа материалын зардал, 4.2 хувийг норматив зардал, 0.04 хувийг эд хогшил худалдан авах зардал, 0.04 хувийг томилолт, зочны зардал, 0.07 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 0.52 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 4.2 хувийг төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төсвөөс 1.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авч, бичиг хэргийн зардалд 0.9 сая төгрөгийг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийг устгал, ариутгалын зардалд 0.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2021 онд гүйцэтгэлээр нийт 2481.8 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Үйл ажиллагаанд зайлшгүй

шаардлагатай цалин, НДШ, халаалт, үдийн цай зэрэг зардлуудыг хасаж тооцоход тэвчиж болох зардлын дүн 143.9 сая төгрөгийн 10 хувь 14.9 сая төгрөгийг хэмнэж ажиллахаас 8.6 сая төгрөгийг хэмнэж /цалингийн зардлаас бусад зардлын хэмнэлт/ төсөвт төвлөрүүлж, 5.7 сая төгрөгийн төсвийг хэмнэж, төсөвт төвлөрүүлээгүй байна.

Үүнээс үзэхэд Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2021 онд 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2490.4 сая төгрөгийн 117 мэдээллийг хугацаандаа байршуулсан, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна. Шилэн дансны 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 249.7 сая төгрөгийн 12 гүйлгээг байршуулсан эсэхийг шалгаж үзэхэд зөрчил дутагдал илрээгүй.Шилэн дансны мэдээллийг оруулсан байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 заалт бүхий зөвлөмж өгөгдөж, хариуг хугацаанд ирүүлж, зөрчлийг давтан гаргаагүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан цалингийн төсвийн зарцуулалтыг бүрэн үзэж чадаагүй тул гүйцэтгэлийн шалгалтаар үзэх шаардлагатай.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6.4 сая төгрөгийн зөрчил илэрч, 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдлөө.

### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.Үүнд:

1. Сургуулийн захирал Ж.Алимад зохих тушаал шийдвэргүйгээр 12 дугаар сард 733.5 мянган төгрөгийн урамшуулалт цалинд олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5-д “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2.1-д *төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид*“”, 1.2.2-т “*төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид*” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

### 4.3 Албан шаардлага

Аудитаар 5.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдлөө.Үүнд:

1.Цэнгэл сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 2490.4 сая төгрөгийн төсөв зарцуулсан бөгөөд зайлшгүй шаардлагатай цалин, НДШ, халаалтын зэрэг зардлуудыг хасаж тооцоход тэвчиж болох зардлын дүн 143.9 сая төгрөгийн 10 хувь 14.4 сая төгрөгийг хэмнэж зарцуулахаас 8.6 сая төгрөгийг /цалингийн зардлаас бусад зардлын хэмнэлт/ төсөвт төвлөрүүлж, 5.7 сая төгрөгийн төсвийг хэмнэж, төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1-т “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3.төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах; Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1-ийн 1.1-д “*үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан*

*төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах талаар албан шаардлага өгөв.

### 4.4 Зөвлөмж

байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль | 2 | 6.4 | | | 1 | 0.7 | 1 | 5.7 | | |